



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 02 өдөр

Дугаар A/337

Арвайхээр

Ажлын хэсэг томилох тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Засгийн газрын 2014 оны "Журам шинэчлэн батлах тухай" 43 дугаар тогтоолын 4.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар тухайн жилд гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Гишүүд: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Газар, байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дотоод хяналтын нэгж (аль нэг гишүүн)

-Тухайн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч (байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн), Байгаль хамгаалагч

-Төрийн бус байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга: -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн (тухайн асуудал хариуцсан)

2. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлыг холбогдох журмын дагуу хүлээн авч, акт үйлдэн танилцуулж байхыг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Баясгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100721

D:My Doc. Zahiramj. Zasag darga